

# МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

## “МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХОС” ХХК-ИЙН НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 23/001

Улаанбаатар хот

*“Мандал Ассет менежмент ҮЦК” ХХК-ийн  
хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний  
2022 оны жилийн тайланг батлах тухай*

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалт, Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.9 дэх заалт, 63 дугаар зүйлийн 63.5 дахь заалт, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалт болон 2023 оны 04 сарын 22-ны өдрийн Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл, Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мандал Ассет менежмент ҮЦК” ХХК-ийн хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний дагуу үзүүлсэн үйлчилгээний 2022 оны жилийн тайланг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ө.ГАНЗОРИГ

# МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

## “МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХОС” ХХК-ИЙН НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 23/002

Улаанбаатар хот

### *Кастодиан банкны хөрөнгө хадгалах үйлчилгээний 2022 оны жилийн тайланг батлах тухай*

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалт, Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.16 дэх заалт, 63 дугаар зүйлийн 63.5 дахь заалт, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалт болон 2023 оны 04 сарын 22-ны өдрийн Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл, Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Голомт банк” ХК-ийн Кастодиан банкны хэлтэстэй байгуулсан хөрөнгө хадгалах үйлчилгээний 2022 оны жилийн тайланг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ө.ГАНЗОРИГ

# МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

## “МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХОС” ХХК-ИЙН НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 23/003

Улаанбаатар хот

### *ХОС-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай*

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалт, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, 63 дугаар зүйлийн 63.5 дахь заалт, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалтуудыг тус тус удирдлага болгон “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн 2022 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, тус тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2023 оны 04 сарын 22-ны өдрийн Нэгж эрх эзэмшигчдийн эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн 2022 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ө.ГАНЗОРИГ

# МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

## “МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХОС” ХХК-ИЙН НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 23/004

Улаанбаатар хот

### *Сангийн бодлогын баримт бичиг, Сангийн танилцуулгад өөрчлөлт оруулах тухай*

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалт, 17 дугаар зүйлийн, Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.16 дэх заалт, 63 дугаар зүйлийн 63.5 дахь заалт, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалт болон 2023 оны 04 сарын 22-ны өдрийн Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл, Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. СЗХ-ны 2022 оны 275 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам шинэчилсэн журам”-д нийцүүлэн “МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН” ХХК-ийн “Хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг” болон “Хөрөнгө оруулалтын сангийн танилцуулга”-д зохих нэмэлт өөрчлөлтийг оруулах эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлд олгосугай.
2. Энэхүү шийдвэрийн 1-д заасны дагуу зохих нэмэлт өөрчлөлтийг оруулж СЗХ-нд бүртгүүлэхийг Сангийн менежерт үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Энхтүвшинд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ө.ГАНЗОРИГ

# МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

## “МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХОС” ХХК-ИЙН НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 23/005

Улаанбаатар хот

### *Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд өөрчлөлт оруулах тухай*

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалт, 47 дугаар зүйл, Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.16 дэх заалт, 63 дугаар зүйлийн 63.5 дахь заалт, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалт, Сангийн дүрмийн 9.3-р зүйлийн 9.3.1 дахь заалт болон 2023 оны 04 сарын 22-ны өдрийн Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл, Тооллогын комиссын дунг үндэслэн ТОГТООХ нь:

1. Сангийн Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний 13.4-д “*Сангаас ХОМК-д тухайн жил төлөх үйлчилгээний төлбөр нь Сангийн цэвэр активын үнэлгээний нэг (1%) хувьтай тэнцүү байх ба уг үйлчилгээний төлбөрийг сар бүрд тэнцүү хувааж ХОМК-д төлнө*” гэж байгааг “*Сангаас ХОМК-д тухайн жил төлөх үйлчилгээний төлбөр нь Сангийн цэвэр активын үнэлгээний (1%) хувьтай тэнцүү байх бөгөөд тус үйлчилгээний төлбөрийг сар бүрийн эцсийн цэвэр хөрөнгийн үнэлгээгээр тооцож дараа сар бүрийн 10-ны дотор нэхэмжлэлийн дагуу ХОМК-д төлнө*” гэж өөрчилсүгэй.
2. Сангийн хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний 13.5-д “*ХОМК-ийн үйлчилгээний төлбөрийг тооцохдоо тухайн жилийн 1-р сарын 16-ны өдрийн цэвэр активын үнэлгээгээр тооцно*” гэж байгааг “*ХОМК-н үйлчилгээний төлбөрийг сар бүрийн эцсийн цэвэр активын үнэлгээгээр тооцно*” гэж өөрчилсүгэй.
3. Дээрх өөрчлөлтийг оруулсан хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг сангийн менежер Г.Ганзоригт даалгасугай.
4. Энэхүү тогтоолоор баталсан хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг сангийн менежер Г.Ганзоригт даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ө.ГАНЗОРИГ

# МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

## “МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХОС” ХХК-ИЙН НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 23/006

Улаанбаатар хот

*ТУЗ-ийн зарим гишүүдийг чөлөөлж,  
нөхөн томилох тухай*

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалт, Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.7 дэх заалт, 63 дугаар зүйлийн 63.5 дахь заалт, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалт, Сангийн дүрмийн 10.3 дах заалт болон 2023 оны 04 сарын 22-ны өдрийн Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл, Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

- Сангийн дараах Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эхийг хугацаанаас нь өмнө буюу 2023 оны 04 сарын 22-ны өдрөөр дуусгавар болгосугай. Үүнд:
  - Өлзийбаяр овогтой Ганзориг
  - Чүлтэм овогтой Даваадаш
- Дараах хүмүүсийг 2023 оны 04 сарын 22-ны өдрөөс эхлэн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр өмнөх Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийн хугацааг дуусах хүртэл хугацаагаар томилсугай. Үүнд:
  - Ринчинням овогтой Амаржаргал
  - Ганболд овогтой Батзориг
- Шинээр томилогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг нэн даруй олон нийтэд мэдээлэх, Хөрөнгийн бирж-д холбогдох бичиг баримт, болон Санхүүгийн зохицуулах хороонд тохиромжтой этгээдээр тодорхойлуулахыг сангийн менежер Г.Ганзоригт даалгасугай.
- Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Энхтүвшинд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ө.ГАНЗОРИГ

# МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

## “МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХОС” ХХК-ИЙН НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 23/007

Улаанбаатар хот

### ТУЗ-ийн 2023 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлах тухай

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалт, Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.13 дэх заалт, 63 дугаар зүйлийн 63.5 дахь заалт, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалт, Сангийн дүрмийн 10.3 дах заалт болон 2023 оны 04 сарын 22-ны өдрийн Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл, Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

- “Мандал ирээдүйн өсөлт хамтын ХОС” ХХК-ны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны зардлын төсвийг дараах бүтэцтэй баталсугай. Үүнд:

Д/д	Зардлын төсөв	Нийт зардал /төгрөг/
1	Бичиг хэргийн зардал	1,000,000
2	ТУЗ-ийн хурлын зардал	3,000,000
3	Нэгж эрх эзэмшигчдийн хурал	10,000,000
	<b>Дүн</b>	<b>14,000,000</b>

- Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Энхтүвшинд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ө.ГАНЗОРИГ

## “МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХОС” ХХК-ИЙН НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 04 сарын 22 өдөр

Улаанбаатар хот

“Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК (цаашид “Компани” гэх)-ийн Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 04 дугаар сарын 22-ны өдөр 11:00 цагаас 13:05 цагийн хооронд цахимаар хуралдаж, хурлын ирц, санал хураалт, асуултыг [www.investmentexpo.mn](http://www.investmentexpo.mn) вэбсайтаар хураав.

**Хурлын дарга:** Өлзийбаярын ГАНЗОРИГ

**Хурлын нарийн бичгийн дарга:** Балдангийн ЭНХТҮВШИН

**Тооллогын комисс:** Г.Баасанбат /Комиссын дарга/

Гишүүд: О.Заяадэлгэр

О.Мягмарсүрэн

**Хуралд оролцсон нэгж эрх эзэмшигч нарын тоо:** 881

**Хуралд оролцсон саналын эрхтэй нэгж эрх эзэмшигч нарын тоо:** 26,553,719 ширхэг

**Хурлын ирц:** 53.11 хувь буюу олонх.

### НЭГ. МЭДЭЭЛЭЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Энхтүвшин “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ны нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдах шийдвэрийг 2023 оны 03 сарын 10-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаас шийдвэрлэсэн тухай мөн уг шийдвэрийн дагуу 2023 оны 03 сарын 15-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржид нэгж эрх эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг хүргүүлсэн тухай танилцуулав. Нэгж эрх эзэмшигчдийн хурлын зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр 2023 оны 03 сарын 15-ны өдөр, 2023 оны 03 сарын 30-ны өдрүүдэд тус тус мэдээлснийг танилцуулав. Хурлын зар болон хурлын материалыг Санхүүгийн зохицуулах хорооны 244 тоот тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-ын дагуу 2023 оны 03 сарын 20-ны өдрийн дотор брокер, дилерийн компаниудад цахим болон хэвлэмэл хэлбэрээр хүргүүлж, нэгж эрх эзэмшигчдийн хурлын материалтай танилцах боломжоор хангаж ажилласан болохыг мэдэгдэв.

Мөн Нэгж эрх эзэмшигчдийн хурлын бүртгэлийн өдрийг 2023 оны 04 сарын 03-ны өдрөөр тогтоосныг танилцуулав.

Тооллогын комиссын дарга Г.Баасанбат:

- Нэгж эрх эзэмшигчдийн хурлын ирц хураалтын аргачлал болон “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн ТУЗ-ийн хурлын шийдвэрээр томилогдсон Тооллогын комиссоос ирүүлсэн нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хуралд ирсэн нэгж эрх эзэмшигчдийн ирцийн бүртгэлийг танилцуулав.
- Хувьцаа эзэмшигчдийн энэ удаагийн ээлжит хуралд 26,553,719.0 ширхэг нэгж эрх эзэмшдэг 881 нэгж эрх эзэмшигч оролцож байгаа нь нийт саналын эрх бүхий 50,000,000.0 ширхэг нэгж эрхийн 53.11% болж байгааг хуралд оролцогчид болон хурлын даргад мэдээлсүгэй.

-  
-

- Компанийн тухай хуулийн 69.1 дэх хэсгийн заалтыг үндэслэн нийт саналын эрхтэй нэгж эрхийн 53.11%-ийг эзэмшигч хуралд оролцож байгаа учраас компанийн нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах болсон шалтгаан, хуулийн үндэслэлийг танилцуулж, хурлаар хэлэлцэх асуудал, хурлын дэгийг танилцуулав.

Нэгж эрх эзэмшигчдийн хурлын дарга Ө.Ганзориг нээлтийн үг хэлснээр хурал албан ёсоор эхлэв.

### **ХОЁР. ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ЖАГСААЛТ**

- 1 дүгээр асуудал:** Сангийн 2022 оны үйл ажиллагааны тайлан танилцуулах;
- 2 дугаар асуудал:** Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн итгэмжлэн удирдах үйлчилгээний 2022 оны жилийн тайланг танилцуулах;
- 3 дугаар асуудал:** Голомт Кастодиан банкны хөрөнгө хадгалах үйлчилгээний 2022 оны жилийн тайлан танилцуулах;
- 4 дүгээр асуудал:** Сангийн 2022 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;
- 5 дугаар асуудал:** Сангийн 2022 оны татварын дараах цэвэр ашгаас ногдол ашиг тараах эсэх талаарх ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах;
- 6 дугаар асуудал:** Сангийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
- 7 дугаар асуудал:** Санд хөрөнгө хадгалах үйлчилгээ үзүүлэгч Кастодиан банкиг солих;
- 8 дугаар асуудал:** Кастодиан банк өөрчлөгдсөнтэй холбогдуулан сангийн дүрэмд өөрчлөлт оруулах;
- 9 дугаар асуудал:** СЗХ-ны шинэчилсэн журамд нийцүүлэн Сангийн ХОББ болон Сангийн танилцуулгад өөрчлөлт оруулах болон үүнтэй холбоотой үүсэх эрхийг ТУЗ-д олгох;
- 10 дугаар асуудал:** Сангийн хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд өөрчлөлт оруулах;
- 11 дугаар асуудал:** ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах;
- 12 дугаар асуудал:** ТУЗ-ийн 2023 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлах;

#### **1 ДҮГЭЭР АСУУДАЛ:**

*Сангийн 2022 оны үйл ажиллагааны тайлан танилцуулах;*

*Танилцуулсан: Сангийн менежер Г.Ганзориг.*

*Танилцуулгын гол агуулга:*

Санг үүсгэн байгуулсан зорилго, философийн талаар танилцуулав. Компанийн хөрөнгө оруулалтын түүх, үйл ажиллагааны тайлан, Төрийн банк, Голомт банк, Хаан банкны IPO-д оролцсон тухай дурдав.

Мөн Хямралтай үед олон улсын сангуудын баримталдаг стратеги, Мандал Ирээдүйн Өсөлт ХОС-н хямралын үеийн стратегиудыг харьцуулан танилцуулав.

#### **2 ДУГААР АСУУДАЛ:**

*Компанийн 2021 оны Менежментийн компанийн итгэмжлэн удирдах үйлчилгээний жилийн тайланг танилцуулах;*

*Танилцуулсан: “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн менежер Г.Ганзориг*

*Танилцуулгын гол агуулга:*

Сангийн хөрөнгө оруулалтын багц болоод цаашид хүлээгдэж буй хөрөнгө оруулалтын талаар болон сангийн цэвэр хөрөнгийн үнэ цэний өнөөгийн болон ирээдүйн төсөөллийн талаар танилцуулав.

# МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

“Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ны  
2023 оны 04-р сарын 22-ны өдрийн  
Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл



### 3 ДУГААР АСУУДАЛ:

**Кастодианд хөрөнгө хадгалах үйлчилгээний жилийн тайланг танилцуулах;**  
Танилцуулсан: “Голомт банк” ХК-ийн Кастодиан банкны хэлтсийн ахлах мэргэжилтэн Э.Батхорлоо  
Танилцуулгын гол агуулга:

<p>Кастодиан банкны үүсэл хөгжил, чиг үүргийн талаар танилцуулж талууд 2021.06.16-нд гэрээ байгуулснаас хойш дараах гол үйлчилгээг үзүүлж байгаа тухай дурдав.</p>	<h4>Кастодиан банк ямар үүрэгтэй вэ</h4> <ol style="list-style-type: none"> <li>01 Сангийн хөрөнгө бүртгэх, төлбөр тооцоо гүйцэтгэх</li> <li>02 Орлого цуглуулах, тайлан мэдээ боловсруулах</li> <li>03 Нэгж эрхийн тухайлсан бүртгэл</li> <li>04 Нэгж эрхийн цэвэр үнэлгээг тооцоолох</li> <li>05 Кастодианы үйлчилгээтэй холбоотой бусад харилцааг зохицуулах</li> </ol>
--	--

# МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

“Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ны  
2023 оны 04-р сарын 22-ны өдрийн  
Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл

Кастодиан нь сан болон ХОМК-ийн үйл ажиллагаанд хяналт тавих гол чиг үүрэгтэй байгууллага билээ.

## Кастодиан банкны хяналтын тогтолцоо



## 4 ДҮГЭЭР АСУУДАЛ:

Компанийн 2021 оны аудитлагдсан санхүүгийн тайлан;

Танилцуулсан: “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн ТУЗ-ийн НБДарга Б.Энхтүвшин



Мүүрс Аудит ХХК  
Улаанбаатар хот, Сэрватар дүүрэг  
Г.р.н.х.б.б. Оймонгийн суудал 775,  
Центрэн тас 9 давхар, 709-ноот  
Утас: +976 7035 0005  
Факс: +976 7035 0001  
И-мэйл: info@moore-mongolia.mn  
www.moore-mongolia.mn

Танилцуулгын гол агуулга:

Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүх материаллаг зүйлийг хамруулан үнэн зөв толилуулагдсан тухай дурдаж “Хараат бус аудиторын дүгнэлт”-ийг уншиж танилцуулав.

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДЭД

Санхүүгийн Тайлангийн Аудитын Тайлан

## Дүгнэлт

Бид “Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын Хөрөнгө оруулалтын сан” ХХК-ийн (цаашид Сан гэж) 2022 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын хурвангүйг багтаасан санхүүгийн тайлангийн тодруулга, тэмдэглэлээс бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, хэвсэргэсэн санхүүгийн тайлангууд нь Сангийн 2022 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээ нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу, бүх материаллаг зүйлийг хамруулан, үнэн зөв толилуулагдсан байна.

## 5 ДУГААР АСУУДАЛ:

Сангийн ногдол ашиг тархах эсэх талаарх ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах;

Танилцуулсан: “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн ТУЗ-ийн НБДарга Б.Энхтүвшин

Танилцуулгын гол агуулга: 2023 оны 02-р сарын 16-ны өдрийн 01 тоот “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн ТУЗ-ийн доорх тогтоолыг уншиж танилцуулав.

**МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ**

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН**

2023 оны 02 сарын 16 өдөр

№ 01

Улаанбаатар хот

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

*“Ногдол ашиг хуваарилах эсэх тухай”*

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, “Мандал Ирээдүйн өсөлт” хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сан (“ХОС” гэх)-ийн дүрмийн 10 дугаар зүйл 10.4.7 хэсгийг тус тус удирдлага болон ХОС-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. Мандал Ирээдүй Өсөлт” хөрөнгө оруулалтын сан нь хөрөнгө оруулалтын бодлогод заасны дагуу эдийн засгийн өсөлтийг хангах зорилгоор 2022 оны цэвэр ашгаас ХОС-ийн нэгж эрх эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.
2. Ногдол ашиг хуваарилахгүй тухай тогтоол мэдэгдлийг ХОС-ийн нэгж эрх эзэмшигчид олон нийт, эрх бүхий байгууллагад мэдэгдэх ажлыг зохион байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргал үүрэг болгосугай.

ДАРГА



Ө.ГАНЗОРИГ

**6 ДУГААР АСУУДАЛ:**

**Сангийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;**

Танилцуулсан: “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн ТУЗ-ийн НБДарга Б.Энхтүвшин

Танилцуулгын гол агуулга: “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн ТУЗ-ийн доорх дүгнэлтийг уншиж танилцуулав.

МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын үргэлжлэл үргэлжлэл

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр үйлдлийн 9.4 дүгээр зүйл, Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 хэсэгт, Сангуудын зохицуулалт хорооны 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 775 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хөрөнгө оруулалтын санг тусгаж байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тухай зөвшөөрөл олгох, тухай хамаат тавих журмыг”ын 9.1, 9.2, “Мандал Хөрөнгөтэй Хамтын ХОС” ХХК (анхандаа “Санд”) тухайн Дүрэм (өнөөгт “Дүрэм” тухайн) 11-р зүйлийн 11.4.5 дэх хэсгийн тус тус үндэстэн ДҮНГЭЭЛТ ГАРГАХ нь:

1. ХОС-ийн жилийн үйл ажиллагааны өмнө дунд мөнгөтэй сангуудийн тайлангийн агуулганд:

“Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын ХОС” ХХК-ийн ТУЗ нь 2022 оны үйл ажиллагаа болон аудитлагдсан сангуудийн тайлангийн талаар мэдэгдэж, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Компанийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын зөвшөөрөлтийн үйл ажиллагаа, эрхлэх тухай зөвшөөрөлтийн журмыг, Хөрөнгө оруулалтын санг тусгаж байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тухай зөвшөөрөл олгох, тухай хамаат тавих журмыг, ХОС-ийн дүрэмийн хүрээнд доорх дүгнэлтийг гаргасан байна. Үүнд, ХОС нь хөрөнгө оруулалтыг хөрөнгө оруулагчид болгохын бэрхшээлгүйгээр дунд мөнгөтэй санг 2022 оны 12 сарын 31-ны байдлаар нэгж эрх эзэмшигчид хөрөнгийн үнэтэй 1,116.07 хуримтлалтай байна. ХОС нь 2022 оны 5.6 тэрбум төгрөгийн нийт орлогоо тайлангаар бүртгэж байсан жилийн нөхөр ашиг 5.1 тэрбум төгрөгт хүртээ. 2022 оны сангийн хөндлөнгөөсний аудитаар олон удаан Мүүр, Аудит ХХК хийсэн бөгөөд 2023 оны 03 сарын 07-ны өдөр гаргасан дүгнэлтээр “Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын ХОС” ХХК-ийн 2022 оны 12 сарын 31-ны өдөр бэлдсэн өөрсөд хэлсэн сангуудийн гүйцэтгэл болон зөвшөөрөл гүйцэтгэл нь Сангуудын Тайлангийн Санг Урьдчилсан (STOPS) -ийн агуу, бүх мэтгэрдээ үүнийг хамруулан, үгүйсгэх төлбөрүүдэд байгаа гэсэн дүгнэлт гаргасан байна.

2. Кастодианы өөрсөд хадгалах үйлчилгээний жилийн тайлан

2022 оны 12 сарын 31-ны өдрийн байдлаар сангийн нэгж эрх эзэмшигч 8,476 иргэн, 24 аж ахуй нэгж, 3 гадаад улсын иргэн байна. 2022 оны 12 сарын 31-ны өдрийн байдлаар Сангийн тэмдэг үндэс 35.7 тэрбум төгрөг, Нэгж эрхийн дөрвөлдөгч 1,114.35 тэрбум байна. 2022 оны жилийн жилийн байдлаар Сангийн орлогоос 12.6 тэрбум төгрөг нь худалдаа, 21.9 тэрбум төгрөг нь Бонд, 20.9 тэрбум төгрөг нь Банкны хадгалмаж, 161.0 сая төгрөг нь бусад мөнгөөр байна. Нийт сангийн хөрөнгийн 51.2 тэрбум төгрөгийн үнэтэй 4.5 тэрбум төгрөгийн аж ахуй нэгж, 17.5 сая төгрөгийн гадаад улсын иргэн хөрөнгөтэй байна. Төлбөртэй хөрөнгө нь 2022 оны жилийн 55.7 тэрбум төгрөгийн хөрөнгө хадгалж, Нэгж эрхийн өмчлөгч үйлчилгээний тооцооллыг 2.48 удаа хийж, 9 сарын тайлан мэдээг төгсгөлтэй байгуулаж, 9,266

МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

арилжав 3,129 үйлчилгээний төлбөр төлөгч гүйцэтгэж, 8,503 нэгж эрх хөрөнгийн үндэс 50.0 сая нэгж эрхийг бүртгэж баталгаажуулсан байна.

3. ХОС-ийн хөрөнгө нэгжлэлт үзвэрээс хөрөнгө хэрэгжүүлэн үйл ажиллагааны тайлан

Үйлчилгээний үйлчилгээ нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Компанийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын бэлдгэлтийн бичиг баримт болон бусад дотоод хууль журмын хүрээнд үйл ажиллагааг явуулах ажлаасан байна. Үүнд, Сангийн хөрөнгө оруулалтын мэдээллийг тухай бүр хүргэх, Сангийн үйл ажиллагааг мэдээллийг тухай бүр хүргэх, ТУЗ-ийн хурал, хуралдуулах сангийн үйл ажиллагааг үр дүн танингуулах, шаардлагатай шийдвэрүүдийг гаргуулах, Зохицуулагч байгууллагуудтай харилцах, Кастодиан банканд сангийн хөрөнгийг хадгалуулах, тайлан мэдээллийг үгүйсгэх болон бусад хэргийг хийх, СХК-ны хяналт ашигдал болон мөнгөтэй сангийн аудит хийлгэх, холбоотой материаллаг бүрдүүлэх, ДҮРМ ажиллагааг биедүүлэх, Төрийн банк болон Голomt банкны хуулийн зөвшөөрөл болж.

Нийт 2022 оны “Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын ХОС” ХХК-ийн хөрөнгө оруулалтын зөвшөөрөлтийн баг тэмдэгээр зөвшөөрөл мөнгөтэй сангуудийн гүйцэтгэл болон зөвшөөрөл бүрэн дүүрэн ажиллагааг амжилттай гүйцэтгэж, ТУЗ-ыг дүгнэж байна.

7 ДУГААР АСУУДАЛ:

Санд Хөрөнгө хадгалах үйлчилгээ үзүүлэгч Кастодиан банкныг солих

Танилцуулсан: “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн ТУЗ-ийн НБДарга Б.Энхтүвшин

Танилцуулгын гол агуулга:

Кастодиан үйлчилгээ: Сангийн хөрөнгийг бүртгэх, төлбөр тооцоо гүйцэтгэх, Орлого цуглуулах, тайлан мэдээ боловсруулах, Нэгж эрхийн тухайлсан бүртгэл, Нэгж эрхийн цэвэр, үнэлгээг тооцоолох, Кастодианы үйлчилгээтэй холбоотой бусад харилцааг зохицуулах зэрэг үйлчилгээ үзүүлдэг талаар товч танилцуулав.

Шимтгэлийн хувьд Голомт банк 0.20%-иар үзүүлж байгаа бөгөөд Худалдаа Хөгжлийн Банк 0.15%-иар тус үйлчилгээг үзүүлэх санал ирүүлсэн.

Голомт банкны зүгээс хөлсөө 0.1% болгох саналаа хурлын материал тарааснаас хойш Санд ирүүлсэн болно. Тиймээс нэгж эрх эзэмшигч нарыг шинэ нөхцөл байдлыг харгалзан үзэж шийдвэрээ гаргахыг хүссэн.

8 ДУГААР АСУУДАЛ:

Кастодиан банк өөрчлөгдсөнтэй холбогдуулах сангийн дүрэмд өөрчлөлт оруулах

Танилцуулсан: “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн ТУЗ-ийн НБДарга Б.Энхтүвшин

Танилцуулгын гол агуулга:

Кастодиан банкныг сольсоор дүрэмд өөрчлөлт оруулна. Учир нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 16.1 “Хөрөнгө оруулалтын сангийн дүрэмд Компанийн тухай хуулийн 16 дугаар

зүйлд зааснаас гадна дараах зүйлийг тусгана” мөн хуулийн 16.1.5-д “Кастодианы үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийн нэр, хуулийн этгээдийн улсын бүртгэл, оршин байгаа газрын хаяг” гэж заасан байдаг тул Сангийн дүрэмд дараах өөрчлөлтийг оруулж байна. гэж заасан байдаг тул хэрэв энэхүү нэгж эрх эзэмшигчдийн хурлаас Кастодиан банкныг солих шийдвэр гарвал Сангийн дүрэмд өөрчлөлт орох шаардлагатайг танилцуулав. Үүнд:

Сангийн дүрмийн 6.2 Хуучин:	Сангийн дүрмийн 6.2 Шинэчилсэн заалт:
Голомт Банк ХХК, РД:2075377, Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө – 24, Паркплэйс барилга, 11 давхар	Худалдаа Хөгжлийн банк ХХК, РД: 2635534, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, энхтайвны өргөн чөлөө, 19, Худалдаа хөгжлийн банк, 14210, өөрийн байр

### **9 ДУГААР АСУУДАЛ:**

***СЗХ-ны шинэчилсэн журамд нийцүүлэн Сангийн ХОББ болон Сангийн танилцуулгад өөрчлөлт оруулах болон үүнтэй холбоотой үүсэх эрхийг ТУЗ-д олгох***

*Танилцуулсан: “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн ТУЗ-ийн НБДарга Б.Энхтүвшин*

*Танилцуулгын гол агуулга:*

Санхүүгийн зохицуулах хороо 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 275 тоот тогтоолын хавсралтаар “Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам”-ыг баталсан.

Энэхүү журмыг 2022 оны 10-р сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр шийдвэр гарсан.

Тус журмын 16.1. Хамтын ХОС-г хөрөнгө оруулалтын стратегиас нь хамааруулан хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг болон нэгж эрхийн танилцуулгад дараах байдлаар ангилж тусгасан байна. Үүнд:

16.1.1. Хувьцааны сан буюу арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй компанийн хувьцаанд хөрөнгө оруулах сан;

16.1.2. Тогтмол орлоготой санхүүгийн хэрэгслийн сан буюу Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг дарга, нийтэд санал болгон гаргасан компанийн өрийн хэрэгсэл, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас зэрэг тогтмол мөнгөн урсгал авах боломжтой санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах сан;

16.1.3. Тэнцвэржүүлсэн сан буюу хувьцааны болон тогтмол орлоготой санхүүгийн хэрэгслийн аль алинд нь хөрөнгө оруулах сан;

16.1.4. Мөнгөний зах зээлийн сан буюу нэг жил хүртэлх хугацаатай тогтмол орлоготой санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах сан;

16.1.5. Үнэт цаасны индексийн сан буюу арилжаа эрхлэх байгууллагаас тооцон гаргадаг индексийн багцад багтдаг үнэт цаасанд хөрөнгө оруулах сан.

Санхүүгийн зохицуулах хорооны Шинэчилсэн журмын дагуу сан нь дээрх 5 ангиллаас аль нэг ангилалд багтах бөгөөд үүнтэй холбоотой Сангийн Хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг болон Сангийн танилцуулгад өөрчлөлт орох шаардлагатай болсон.

Тиймээс нэгж эрх эзэмшигчдийн хурлаас “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн “Хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг” болон “Хөрөнгө оруулалтын сангийн танилцуулгад” өөрчлөлт оруулах эрхийг Сангийн Төлөөлөн удирдах зөвлөлд олгох санал оруулж байна.

### **10 ДУГААР АСУУДАЛ:**

***Сангийн хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд өөрчлөлт оруулах***

Танилцуулсан: “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн ТУЗ-ийн НБДарга Б.Энхтүвшин

Танилцуулгын гол агуулга:

“Мандал Ассет Менежмент ҮКЦ” ХХК болон “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн хооронд 2021 оны 06 сарын 15-ны өдрийн 21/001 тоот “Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын хөрөнгө оруулалтын сангийн Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ”-г зурсан.

Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн зүгээс тус гэрээнд дараах өөрчлөлт оруулах саналтай байна. Үүнд:

Сангийн Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний 13.4-д “Сангаас ХОМК-д тухайн жил төлөх үйлчилгээний төлбөр нь Сангийн цэвэр активын үнэлгээний нэг (1%) хувьтай тэнцүү байх ба уг үйлчилгээний төлбөрийг сар бүрд тэнцүү хувааж ХОМК-д төлнө” гэж байгааг “Сангаас ХОМК-д тухайн жил төлөх үйлчилгээний төлбөр нь Сангийн цэвэр активын үнэлгээний (1%) хувьтай тэнцүү байх бөгөөд тус үйлчилгээний төлбөрийг сар бүрийн эцсийн цэвэр хөрөнгийн үнэлгээгээр тооцож дараа сар бүрийн 10-ны дотор нэхэмжлэлийн дагуу ХОМК-д төлнө” гэж өөрчлөх.

Сангийн хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний 13.5-д “ХОМК-ийн үйлчилгээний төлбөрийг тооцоходоо тухайн жилийн 1-р сарын 16-ны өдрийн цэвэр активын үнэлгээгээр тооцно” гэж байгааг “ХОМК-н үйлчилгээний төлбөрийг сар бүрийн эцсийн цэвэр активын үнэлгээгээр тооцно” гэж өөрчлөх санал энэхүү нэгж эрх эзэмшигчдийн хурлаар оруулж байгааг танилцуулав.

**11 ДУГААР АСУУДАЛ:**

**ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах**

Танилцуулсан: “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн ТУЗ-ийн НБДарга Б.Энхтүвшин

Танилцуулгын гол агуулга:

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 05 сарын 25-ны өдрийн 275 тоот тогтоолоор баталсан “Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам” батлагдсан.

Тус журмын 10-р зүйл “ХОС-ийн төлөөлөн удирдах зөвлөл”. 10.9-д Хуульд өөрөөр заагаагүй бол ХОМК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага нь хамтын ХОС-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүний ажлыг давхар хавсран эрхлэхгүй” гэж заасан байна.

Тиймээс “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Ө.Ганзоригийг ТУЗ-ийн үүрэгт ажлаас чөлөөлөх шийдвэрийг “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн Нэгж эрх эзэмшигчдийн хурлаар шийдвэрлүүлэх санал оруулж байна.

Ч.Даваадаш нь Мандал Даатгал ХК-ны Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчээр ажиллаж байсан бөгөөд 2022 онд үүрэгт ажлаасаа өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн.

**Хэлэлцэх асуудал 11:**  
**Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшигч Р.Амаржаргал**



№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элсэн он	Төгссөн он
1	14-р сургууль	Бүрэн дунд боловсрол	1968	1973
2	УААДС, Москва, ЗХУ	Эдийн засагч	1976	1982
3	Брэд Фордын Их Сургууль	Макро эдийн засгийн бодлого төлөвлөлт магистр	1994	1995
4	Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд цолтой			

№	Хаана ажиллаж байсан	Албан тушаал	Ажилд орсон огноо	Ажлаас гарсан огноо
1	МҮЭТ Зөвлөл	Зааварлагч	1982	1983
2	ЦНД Сургуульд	Багш	1983	1991
3	ТИСургуульд	Багш		
4	Эдийн засгийн Коллеж	Захирал	1991	1996
5	Засгийн газар	Сайд	1998	1999
6	Засгийн газар	Ерөнхий сайд	1999	2000
7	УИХ	Гишүүн	1996, 2004, 2008, 2012	2016



Тиймээс “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Ч.Даваадашийг ТУЗ-ийн үүрэгт ажлаас чөлөөлөх шийдвэрийг “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн Нэгж эрх эзэмшигчдийн хурлаар шийдвэрлүүлэх санал оруулж байна.

**Хэлэлцэх асуудал 11:**



**Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшигч Г.Батзориг**



№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Ховд аймаг, 1-р сургууль	Бүрэн дунд боловсрол	1998	2008
2	МУИС, Эдийн Засгийн Сургууль	Эдийн засагч	2008	2012
3	Турк, Сакарья Их Сургууль	Эдийн засагч, Магистр	2015	2018

№	Хаана ажиллаж байсан	Албан тушаал	Ажилд орсон огноо	Ажлаас гарсан огноо
1	Грандлайн ҮЦК	Макро шинжээч	2012	2013
2	ХасБанк	Макро шинжээч	2013	2015
3	Голомт банк	Ахлах эдийн засагч	2018	2020
4	Мандал Санхүүгийн Нэгдэл	Ерөнхий эдийн засагч	2020 оноос хойш	

**12 ДУГААР АСУУДАЛ:**

**Сангийн ТУЗ-ийн 2022 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлах;**

Танилцуулсан: “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн ТУЗ-ийн НБДарга Б.Энхтүвшин

Танилцуулгын гол агуулга:

**1. Хэлэлцсэн нь:**

Танилцуулсан: “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Энхтүвшин

Сангийн ТУЗ-ийн 2023 оны үйл ажиллагааны зардлын төсвийг дараах бүтэцтэйгээр батлуулахаар Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулав. Үүнд:

№	Зардлын төсөв	Нийт зардал /сая₮/
1	Бичиг хэргийн зардал	1.0
2	ТУЗ-ийн хурлын зардал	3.0
3	Нэгж эрх эзэмшигчдийн хурал	10.0
	<b>Дун</b>	<b>14.0</b>

**Асуулт, Хариулт**

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга асуулт хариулт эхэлснийг зарлаж тооллогын комиссын даргаас нэгж эрх эзэмшигч нараас ирсэн асуултуудыг авав. Цахим хэлбэрээр нэгж эрх эзэмшигчдээс асуулт авч байгаа бөгөөд, бүх нэгж эрх эзэмшигчдийн асуултад хариулах боломжгүй тул асуултуудыг агуулгын хувьд ижил болон олон давхацсан гурван асуултуудад хариулахаар сонгосныг тайлбарлав.

**Асуулт 1:**

Сан нь банкны IPO-д оролцсон үлдсэн 2 банкны IPO-д оролцох уу? Хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэхээр ирэх онуудад хэрхэн ажиллахаар төлөвлөж байна вэ?

**Хариулт (товч): Сангийн менежер Г.Ганзориг:**

Хоёр банканд хөрөнгө оруулалт хийхийг тухайн үеийн банкны үнэлгээ болон бусад нөхцөл байдлаас хамаарна. Урт хугацаандаа 2031 он гэхэд анх оруулсан хөрөнгө оруулалтыг 4 дахин нэмэгдүүлэхийг зорьж байна. Энэ хүртэл 2 том хямралыг даван туулна. Үүний хүрээнд хөрөнгө

оруулалтын стратегиа хүнд үед эрсдэл багатай бондын хөрөнгө оруулалтыг хийх, эдийн засгийн өсөлттэй үед хувьцааны хөрөнгө оруулалтыг хийхээр төлөвлөж байна. Хувьцаанд хөрөнгө оруулалт хийхдээ засаглал сайтай компанийг сонгохоор байна. Эдгээр стратегийг баримталснаар ирээдүйд хамгийн найдвартай, хамгийн өндөр өгөөжтэй ажиллаж чадна гэдэгт итгэж байна.

**Асуулт 2:**

*Сан байгуулагдсанаасаа хойш хараахан ногдол ашиг тараагаагүй байна. Ногдол ашиг тараах дээр ямар бодлого баримталж байна вэ?*

**Хариулт (товч): Сангийн менежер Г.Ганзориг:**

Өгөөжөөс өгөөж тооцох стратегийг баримталж байна. Энэ нь бид ногдол ашиг тараах биш харин тэр ашгаа дахин хөрөнгө оруулалт хийж түүнээсээ өгөөж хүртэх гэсэн үг юм. Ингэснээр бид илүү өндөр өгөөж олох боломжтой болно.

**Асуулт 3:**

*Сангийн хувьцааны болон NAV-ийн ялгаа нь юу вэ? Яагаад зөрүүтэй байгаад байна вэ? Хэдийгээр NAV өндөр боловч ханш яагаад унаад байна вэ?*

**Хариулт (товч): Сангийн менежер Г.Ганзориг:**

Цэвэр зах зээлийн хөрвөх чадвартай холбоотой. Сан 10 жилийн хугацаатай байгуулагдсан. Бидний зорилго бол NAV дээр анхаарч хөрөнгө оруулалтын багцыг удирдаж цэвэр хөрөнгийн үнэлгээгээр сангийн хугацаа дуусгахад өгөөж өгдөг гэдгээрээ онцлогтой бол. Зах зээлийн үнэлгээний хувьд бирж дээр хийгдэж байгаа хэлцлийн л үнэ юм.

Иймд хөрөнгө оруулагчид NAV дээр илүү анхаараасай гэж хүсэж байна.

**САНАЛ ХУРААЛТ**

**Танилцуулсан:** Тооллогын комиссын дарга Г.Баасанбат;

**Танилцуулгын гол агуулга:**

Тооллогын комиссын дарга Г.Баасанбат: Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлаас гарч буй тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулав. Үүнд:

Компанийн тухай хуулийн 67-р зүйлийн 67.3.8 дах заалт, 72-р зүйл, “МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХОС” ХХК-ийн нэг эрх эзэмшигчдийн 2023 оны 04-р сарын 22-ны өдрийн ээлжит хуралд санал хураалтаар ирүүлсэн санал хураах хуудсыг тоолсон Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХОС”-ийн нэгж эрх эзэмшигчдийн хурлаар хэлэлцсэн асуудлуудаар санал хураасан дүн дараах байдалтай байгааг хуралд оролцогч нэгж эрх эзэмшигчдэд мэдээлсүтэй. Үүнд:
  - 1.1. Мандал Ассет Менежмент ҮЦК” ХХК-ийн хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний 2022 оны жилийн тайланг хэлэлцэж батлахыг Зөвшөөрсөн 15,863,409.00 ширхэг нэгж эрх буюу 93.12%, татгалзсан 631,349.00 ширхэг нэгж эрх буюу 3.71%, түдгэлзсэн 539,972.00 ширхэг нэгж эрх буюу 3.17% байна.
  - 1.2. Голомт Кастодиан банкны хөрөнгө хадгалах гэрээний 2022 оны жилийн тайланг хэлэлцэж батлахыг Зөвшөөрсөн 15,430,249.00 ширхэг нэгж эрх буюу 92.05%, татгалзсан 1,042,019.00 ширхэг нэгж эрх буюу 6.22%, түдгэлзсэн 291,527.00 ширхэг нэгж эрх буюу 1.74% байна.
  - 1.3. Сангийн 2022 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлахыг Зөвшөөрсөн 15,445,510.00 ширхэг нэгж эрх буюу 91.27%, татгалзсан 961,619.00 ширхэг нэгж эрх буюу 5.68%, түдгэлзсэн 516,057.0 ширхэг нэгж эрх буюу 3.05% байна.
  - 1.4. Голомт Кастодиан банктай байгуулсан хөрөнгө хадгалах үйлчилгээний гэрээг цуцлах, Худалдаа хөгжлийн банкны Кастодиан хэлтэстэй хөрөнгө хадгалах үйлчилгээний гэрээ байгуулах эрхийг сангийн менежер Г.Ганзоригт олгохыг Зөвшөөрсөн 3,561,667.00 ширхэг нэгж эрх буюу 21.07%, татгалзсан 12,282,910.00 ширхэг нэгж эрх буюу 72.65%, түдгэлзсэн 1,062,979.00 ширхэг нэгж эрх буюу 6.29% байна.

- 1.5. СЗХ-ны шинэчилсэн журамд нийцүүлэн Сангийн ХОББ болон Сангийн танилцуулгад өөрчлөлт оруулах болон үүнтэй холбоотой үүсэх эрхийг ТУЗ-д олгохыг хэлэлцэж Зөвшөөрсөн 15,450,132.00 ширхэг нэгж эрх буюу 92.56%, татгалзсан 943,689.00 ширхэг нэгж эрх буюу 5.65%, түдгэлзсэн 298,564.00 ширхэг нэгж эрх буюу 1.79% байна.
- 1.6. Сангаас ХОМК-д тухайн жил төлөх үйлчилгээний төлбөр нь Сангийн цэвэр активын үнэлгээний (1%) хувьтай тэнцүү байх бөгөөд тус үйлчилгээний төлбөрийг сар бүрийн эцсийн цэвэр хөрөнгийн үнэлгээгээр тооцож дараа сар бүрийн 10-ны дотор нэхэмжлэлийн дагуу ХОМК-д төлнө болгож өөрчлөхийг хэлэлцэж Зөвшөөрсөн 11,560,892.00 ширхэг нэгж эрх буюу 70.48%, татгалзсан 2,303,123.00 ширхэг нэгж эрх буюу 14.04%, түдгэлзсэн 2,539,143.00 ширхэг нэгж эрх буюу 15.48% байна.
- 1.7. ХОМК-н үйлчилгээний төлбөрийг сар бүрийн эцсийн цэвэр активын үнэлгээгээр тооцно болгож өөрчлөхыг хэлэлцэж Зөвшөөрсөн 11,441,481.00 ширхэг нэгж эрх буюу 69.05%, татгалзсан 2,668,152.00 ширхэг нэгж эрх буюу 16.10%, түдгэлзсэн 2,459,898.00 ширхэг нэгж эрх буюу 14.85% байна.
- 1.8. ТУЗ-ийн ердийн гишүүн Өлзийбаяр овогтой Ганзоригийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгохыг хэлэлцэж Зөвшөөрсөн 9,831,002.00 ширхэг нэгж эрх буюу 58.68%, татгалзсан 4,447,481.00 ширхэг нэгж эрх буюу 26.55%, түдгэлзсэн 2,474,022.00 ширхэг нэгж эрх буюу 14.77% байна.
- 1.9. ТУЗ-ийн ердийн гишүүн Чүлтэм овогтой Даваадашийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгохыг хэлэлцэж Зөвшөөрсөн 14,388,041.00 ширхэг нэгж эрх буюу 87.05%, татгалзсан 1,677,562.00 ширхэг нэгж эрх буюу 10.15%, түдгэлзсэн 462,417.00 ширхэг нэгж эрх буюу 2.80% байна.
- 1.10. ТУЗ-ийн ердийн гишүүнээр Ринчинням овогтой Амаржаргалыг сонгохыг хэлэлцэж Зөвшөөрсөн 21,795,686.00 ширхэг нэгж эрх буюу 76.60%, татгалзсан 6,656,958.00 ширхэг нэгж эрх буюу 23.40 % байна.
- 1.11. ТУЗ-ийн ердийн гишүүнээр Ганболд овогтой Батзоригийг сонгохыг хэлэлцэж Зөвшөөрсөн 21,800,188.00 ширхэг нэгж эрх буюу 81.83%, татгалзсан 4,840,825.00 ширхэг нэгж эрх буюу 18.17% байна.
- 1.12. ТУЗ-ийн 2023 оны үйл ажиллагааны зардлын төсөв хэлэлцэж батлахыг Зөвшөөрсөн 14,536,529.00 ширхэг нэгж эрх буюу 85.81%, татгалзсан 1,347,756.00 ширхэг нэгж эрх буюу 7.96%, түдгэлзсэн 1,056,168.00 ширхэг нэгж эрх буюу 6.23% байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлаас гарч буй нэгж эрх эзэмшигчдийн хурлын тогтоолыг уншиж танилцуулав.

Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлыг хааж Сангийн менежер Г.Ганзориг хаалтыг үгийг хэлснээр 13 цаг 05 минутад хурал өндөрлөв.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Б.ЭНХТУВШИН

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга

ТАНИЛЦААН:

Ө.ГАНЗОРИГ  
Хурлын дарга

